



**ДОРНОГОВЬ АЙМГИЙН
СОЁЛ, УРЛАГИЙН
ГАЗАР**

**БАЙГУУЛЛАГЫН 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЭХНИЙ
ХАГАС ЖИЛИЙН БИЕЛЭЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,
ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

2024 ОН

БАЙГУУЛЛАГЫН 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЭХНИЙ ХАГАС
ЖИЛИЙН БИЕЛЭЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ
ТАЙЛАН

2024 оны 7 дугаар сарын 9-ны өдөр

Сайншанд сум

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго

Дорноговь аймгийн Соёл, урлагийн газрын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээний гүйцэтгэлийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж удирдлага болон хэрэглэгчдийг шаардлагатай мэдээллээр хангах, цаашид соёлын салбарын үйл ажиллагааг орон нутагт үр нөлөөтэй зохион байгуулахын тулд төлөвлөлт, гүйцэтгэлийн үйл ажиллагааг сайжруулах зорилгоор үнэлгээний ажлыг зохион байгуулав.

Хоёр. Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх үндэслэл, арга зүй

Хяналт-шинжилгээ, үнэлгээг Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”, Аймгийн Засаг даргын 2022 оны А/675 дугаар захирамжаар батлагдсан “Аргачлал батлах тухай” журмыг үндэслэн биелэлт гаргасан заалтын тоо, тайланд тавигдах шаардлагыг хангасан байдалд хяналт-шинжилгээ хийж, үнэлсэн.

Гурав. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн

Соёл, урлагийн газрын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан, хариуцсан мэргэжилтнүүдээс тодруулга авах, бодит гүйцэтгэлийг нягтлан шалгах зэрэг аргуудыг хэрэглэн хяналт, шинжилгээ үнэлгээг хийлээ.

Тус бодлогын баримт бичгийн 8 зорилт 57 арга хэмжээний 2024 оны эхний хагас жилийн хэрэгжилтийн тайланг нэгтгэн, зорилт арга хэмжээ бүрээр хяналт-шинжилгээ, үнэлгээг хийлээ.

№	Зорилт	Үнэлгээ							ХБ	Нийт заалт	Нийт дундаж
		100%	90%	70%	50%	30%	0%				
1	Соёл урлагийн тогтвортой хөгжлийн зорилтыг хангаж, “Цахим соёл” арга хэмжээг нэмэгдүүлнэ	1		1	2				4	67.5%	
2	Соён гэгээрүүлэх үйл ажиллагааг идэвхжүүлж, орон нутгийн онцлог шингэсэн соёлын үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлнэ	10	4						14	97.1%	

3	Соёлын биет болон биет бус өвийн хадгалалт, хамгаалалтыг сайжруулан, өвлөн уламжлуулах, олон нийтэд түгээн дэлгэрүүлэх ажлыг зохион байгуулна	1	3	-	2	2	1		9	66.2%
4	Үндэсний бахархал, монгол өв соёлыг өвлүүлж стандартын шаардлагад нийцсэн соёл, урлагийн барилга байгууламжийн тоог нэмэгдүүлнэ.		1	1	1			8	11	70%
5	Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэх чиглэлээр	2	2						4	95%
6	Гадаад жуулчдын тоог нэмэгдүүлэх	2	1						3	96.6%
7	Хуулиар тусгайлан олгосон чиг үүрэг	1						1	2	100%
8	Хуулиар олгосон нийтлэг чиг үүрэг	7	1	1				1	10	93.3%
Дундаж		34	12	3	5	2	1	10	57	85.1%

Дөрөв. Дүгнэлт

Байгууллагын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж дараах ажлуудыг үр дүнтэй зохион байгуулж ажилласан байна. Үүнд:

- ✓ ЮНЕСКО-гийн Хүн төрөлхтний соёлын биет бус өвийн төлөөллийн жагсаалтад бүртгэгдсэн монгол гэрийг хүүхэд залууст болон Монгол улсыг зорин ирсэн жуулчдад “Монгол гэрийн уламжлалт урлал, зан үйл”-ийг суртачлан таниулах зорилгоор Соёлын яам, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Соёл, урлагийн газраас санаачлан зохион байгуулсан “Монгол гэр” үзэсгэлэн арга хэмжээнд халх угсаатны модон сийлбэртэй их 8 ханатай “Ноён хутагтын өргөө” гэрээр уламжлалт гар урлалын өвлөн уламжлагчдын бүтээлийг 9 хоногийн турш Улаанбаатар хотын төв талбайд сурталчлан алдаршууллаа. Үзэсгэлэнгээр зочилсон зочдын тоо 10,000 гаруй, боловсролын хөтөлбөрт 1700 гаруй хүн хамрагдсан. Тус арга хэмжээний зардалд орон нутгийн төсвөөс аймгийн Засаг даргын 2024 оны А/393 дугаар захирамжаар 10 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. Соёл урлагийн газраас санаачлан хэрэгжүүлсэн “Монгол гэр-Соёлын орон зай” хөтөлбөрт соёлын биет бус өвийн уламжлалт баяр наадам, зан үйл, ёс, тоглоом наадам, уриа дуудлагын ай савын төрлүүд болох монгол шатрын тоглоом наадгай, шагайн харвааг танилцуулан шатар болон шагайн холбоо, өвлөн уламжлагч нартай хамтран ажиллаж 950 гаруй иргэнийг хамрууллаа.
- ✓ Салбарын нийт байгууллагуудыг үндэсний бичгийн булантай болох үүрэг чиглэл өгснөөр Иххэт, Зүүнбаян, Хатанбулаг, Эрдэнэ, Даланжаргалан, Мандах,

Хөвсгөл сумдууд болон СУГ, үндэсний бичгийн буланг байгуулан ажиллалаа. Хагас жилийн байдлаар 8 байгууллага үндэсний бичгийн булан байгуулан хос бичгээр мэдээ мэдээллийг албан хаагчдад хүргэн ажиллаж байна. Эх хэлний өдрийг тохиолдуулан аймгийн төв номын сангаас үндэсний бичгийн уралдааныг салбарын хэмжээнд зохион байгуулж СУГ-ын баг хамт олон тэргүүн байр эзэлсэн. Насан туршийн суралцахуйн төв, Боловсрол шинжлэх ухааны газартай хамтран ЕБ-ын 12 дугаар ангийн сурагчдын дунд "Тунгаамал" үндэсний бичгийн уралдааныг зохион байгуулж 36 сурагч хамрагдаж ЕБ-ын 5-р сургуулийн сурагчид тэргүүн байр эзэллээ. Энэ үеэр сургуулиуд үндэсний бичиг, уран бичвэр, таталган бичгийн үзэсгэлэн гаргалаа. Аймгийн төв номын сан МССТ -ийн 23 албан хаагч үндэсний бичгийн сургалтад хамрагдахаас гадна аймгийн төвийн соёлын байгууллагууд нь мэдээллийн самбарыг хос бичгээр хөтлөн явуулж хэвшлээ.

Төрийн албан хаагчдын дунд "Тунгаамал" "Үсэглэлийн хаад" тэмцээнийг Насан туршийн суралцахуйн төв, БШУГ-тай хамтран зохион байгуулж Стандарт хэмжил зүйн хэлтэс, ШШГГазар, ЭМГазар, 8-р цэцэрлэг, 12 дугаар цэцэрлэгийн 5 баг оролцлоо. Мөн "Үсэглэлийн хаад" тэмцээнийг аймгийн төрийн албан хаагчдын дунд зохион байгуулж 20 гаруй байгууллагын 78 албан хаагчийг хамруулан зохион байгуулж бүх нийтээр хос бичигтэн болоход уриаллаа.

✓ Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 13-р тогтоолоор батлагдсан "Улсын хамгаалалтад байх түүх соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалт"-д Дорноговь аймгаас түүх соёлын үл хөдлөх 6 дурсгал улсын хамгаалалтад бүртгэгдсэн. Он гарснаар Сайхандулаан сумын нутагт орших "Хар хөтлийн палеонтологийн дурсгалт газар", Мандах сумын нутаг дэвсгэрт орших "Сүйхэнтийн палеонтологийн дурсгалт газар"-ыг сумын иргэдтэй хариуцуулан хамгаалуулах гэрээ байгуулж аймгийн хэмжээнд улсын хамгаалалтад орсон 6 үл хөдлөх дурсгалыг иргэдэд 100% гэрээгээр хариуцуулан хамгаалууллаа. Тайлант оны хагас жилийн байдлаар аймгийн хамгаалалт бүхий 14 дурсгалыг иргэн хуулийн этгээдэд гэрээгээр хариуцуулж ажиллалаа.

Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд Замын-Үүд сумын Гаальд хураагдсан түүх соёлын дурсгалт зүйлсийг Замын-Үүд сум дахь сум дундын шүүхийн шийтгэврээр 35 судар номыг Музей, сургалт судалгааны төвийн сан хөмрөгт шилжүүлэн баримтат өвд бүртгэн авч ажиллалаа.

Тав. Үнэлгээ

Соёл, урлагийн газрын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт тооцох 57 арга хэмжээнээс , 34 арга хэмжээ 100 хувийн биелэлттэй, 12 арга хэмжээ 90 хувь, 3 арга хэмжээ 70 хувь, 5 арга хэмжээ 50 хувь, 2 арга хэмжээ 30 хувь, 1 арга хэмжээ 0 хувийн биелэлттэй, хугацаа болоогүй 10 арга хэмжээ байна гэж дүгнэн биелэлтийн дунджийг "Тодорхой үр дүнд хүрсэн" буюу 85,1% гэж үнэллээ.

Зургаа. Цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ, зөвлөмж

Байгууллагын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг эхний хагас жилд хэрэгжүүлж "Тодорхой үр дүнд хүрсэн" гэж үнэлэгдсэн хэдий ч хэрэгжилтийн үр нөлөөг нэмэгдүүлэх чиглэлээр дараах зөвлөмжийг бодлогын асуудал хариуцсан мэргэжилтнүүдэд хүргэж байна.

Бодлогын асуудал хариуцсан мэргэжилтнүүд хэрэгжилт 30 хувьтай буюу “Үр дүнгүй” гэж үнэлэгдсэн арга хэмжээнүүдийг онцгой анхаарч, хэрэгжилтийг эрчимжүүлж, үр дүнг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

Мөн нийтлэг зөвлөмжийг хүргэж байна. Үүнд:

- ✓ Тайланг бичихдээ тайланд тавигдах стандартыг бүрэн хангах /Оршил хэсэг, Үндсэн хэсэг, Дүгнэлт хэсэгтэй байх/
- ✓ Зөвхөн байгууллагын хэмжээнд бус салбарын хэмжээнд хийгдсэн ажлуудыг нэгтгэж тайлагнах
- ✓ Зорилт, арга хэмжээг урьдчилан тодорхойлсон шалгуур үзүүлэлтийн дагуу тайлагнах
- ✓ Хэрэгжилтэд гарсан өөрчлөлт, ахиц үр дүнг заавал тоон мэдээлэлтэй бүрэн тайлагнах, бодитой үнэлэгдэхүйц тайлагнах шаардлагатай.
- ✓ Өөр арга хэмжээг холбож нуршиж бичихгүй байх, мэдээ мэдээлэл биш тайлан хэлбэрээр бичихэд анхаарах
- ✓ Хийгдсэн ажлуудыг орхигдуулалгүй бүрэн гүйцэд, нуршилгүй, товч тодорхой тайлагнах хэрэгтэй.

ХЯНАСАН:

СОЁЛ, УРЛАГИЙН ГАЗРЫН ДАРГА



У.ГАНБААТАР

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, СТАТИСТИК

МЭДЭЭ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

А.НАРАНЖАРГАЛ